

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн нэр шилжүүлэхээр хүсэлт гаргасан 3 /гурав/ иргэний газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэн хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэн баталгаажуулсан 2017 оны А895 дугаар захирамжийн Палам Эрээндээ, 2008 оны 253 дугаар захирамжийн Өлзий Мөнхтулга, 2015 оны А/138 дугаар захирамжийн Занданхүү Нарантунгалаг нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх шилжүүлэн авсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба /Ж.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ